Орчны тойм
М1:4000



Халаалтын 2-р хэсгийн дулаан ачаалал /Гкал/цаг/

	Нэр	Qхалаалт Гкал/цаг	Qхху Гкал/цаг	Qнийт Гкал/цаг
1	УБДС хийсэн тооцоонд хамрагдсан барилгууд	5.02	1.29	6.31
2	Нэмж тооцсон барилгууд	0.58	0.20	0.78
3	Ерөнхий төлөвлөгөөгөөр нэмэгдэх барилгууд	1.94	1.16	3.10
3	Буулгах барилгууд	0.17	0.05	0.22
	Нийт дүн	7.36	2.60	9.96

Тайлбар

1. Энэхүү ажлын зурагт Төв аймгийн Зуунмод хотод Дулааны станц төлөвлөж буйтай холбогдуулан "Төв чандмань-ДЭХГ" ОНӨААТҮГ-ын харьяа Халаалтын 2-р хэсгийн одоо байгаа шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, хэрэглээний халуун усны шугам нэмж төлөвлөх ажлын хүрээнд 2020-2023 онд хийгдсэн барилга угсралтын ажил, шинээр батлагдсан зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу БХТ-ийн 205/2020 тоот магадлалын дүгнэлтээр баталгаажсан ДНТ-10/2019 шифртэй ажлын зурагт хийгдэх тодотгол шинэчэлтийг тусгав.
2. Зураг төслийг Төв аймгийн ЗДТГ, ГХБХБГ-ын захиалгаар дор дурьдсан техникийн бичиг баримтыг үндэслэн боловсруулав. Үүнд:
   - Зураг төсөл боловсруулах 2024.04.20-ны өдрийн ЗТ-04/24 тоот гэрээ
   - Төв аймгийн БЗОСК-ийн захирал Д.Ганбаярын баталсан 2019 оны 03 сарын 20-ны өдрийн 28/17 тоот зургийн даалгавар, ГХБХБГ-ын дарга Б.Насанжаргалын баталсан 2024.04.15-ны өдрийн 09/24 тоот зургийн даалгавар
   - Төв аймгийн Ерөнхий архитектороос өгсөн ойрын жилүүдэд Ерөнхий төлөвлөгөөний дагуу нэмэгдэх барилгууд, аймгийн төвийн дэвсгэр зураг
   - "Төв чандмань ДЭХГ" ОНӨААТҮГ ын 2019 оны 05 сарын 17 өдрийн 142 тоот техникийн нөхцөл
   - БХТ-ийн 2020.02.14-ны өдрийн 205/2020 тоот магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан ДНТ-10/2019 шифртэй ажлын зураг төсөл
   - "УБДС" ТӨХК аар хийлгүүлсэн халаалтын бүх хэсгүүдийн ачааллын тооцоо
   - Газар дээр хийсэн хэмжилтийг үндэслэн холбогдон норм дүрэм
   - БНбД 41-02-13 "Дулааны сүлжээ"
   - БНбД 23-01-09 "Барилгад хэрэглэх геофизикийн үзүүлэлт"-ийн дагуу тус тус боловсруулав.
4. Барилга баригдах газрын цаг уурын нөхцөл:
   - Гадна агаарын тооцоот температур: Хамгийн хүйтэн 5 хоног-(-30,6) хэм /Зуунмод хот/
   - Галлагааны хугацааны үргэлжлэх хугацаа - 230 хоног
   - Салхины дундаж хурд - 3,9м/с
5. Шугам дахь дулаан зөөгч -Ус. Дулаан зөөгчийн температур: Өгөх шугамд /95°С/, Буцах шугамд /70°С/
6. Зуунмод хотод Дулаан станц барих төслийн хүрээнд Халаалтын 2-р хэсэгт шугам сүлжээнд холбогдсон ба холбогдох боломжтой барилгууд болон Ерөнхий төлөвлөгөөгөөр ойрын жилүүдэд баригдах барилгуудын нийт халаалтын ачаалал нь 7.36 Гкал/цаг, хэрэгцээний халуун ус /ХХУ/-ны ачаалал нь 2.6 Гкал/цаг болж байна.
7. Энэхүү 2-р хэлхээний шугам сүлжээг төлөвлөж буй Дулааны станц болон Дулаан хуваарилах төвийн ачаалалтай уялдуулан үе шаттайгаар холбож ашиглана. 2020-2023 онд Халаалтын 2-р зуухны ДХ-13 -с ДХ-17 хүртэл нийт 197,5 у/м шугам хоолойн угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн тул энэхүү зураг төслөөр энэ хэсгийн шугам сүлжээг зөвхөн уялдуулж харна. Ажлын тоо хэмжээ нь материалын түүврээс хасагдсан.
8. Өгөгдсөн зургийн даалгаврын дагуу халаалтын 2-р хэсгийн төв шугамуудын трассын дагуу тоосго, чулуу, блокоор өрсөн ба цаашид ашиглалтын шаардлага хангахгүй бетон суваг, худаг болон шугамуудыг буулган шинээр төмөр бетон онгоцон суваг угсарна. Ерөнхий төлөвлөгөөний дагуу ойрын жилүүдэд барихаар төлөвлөгдсөн 10-н давхар барилгуудыг ДХ-1 ээс зүүн тийш гарсан салааг өргөтгөж холбохоор төлөвлөв. Асфальтон хучилттай автозамтай огтлох хэсэгт нэвтрэх суваг угсарна.
9. Нийт 71-н дулааны худаг, 76 үл хөдлөх тулгуур, 24 эргэлтийн өнцөг, 48-н "П" хэлбэрийн компенсатор /зөөлөвч/-ын нишийг газар дээр нь цутгаж хийнэ. Бетон эдэлхүүний шороо хөрстэй харьцах гадаргууд халуун битум түрхлэг 2 үе хийж ус чийгнээс хамгаална. Худаг, сувгийн хучилт, таг хийцүүдийг хооронд нь цементэн зуурмагаар гагнаж ус орохоос сэргийлнэ.
10. Ст20 маркийн ган хоолойнуудыг үл нэвтрэх цутгамал бетон сувагт гулсах тулгуур, бетон дэр дээр угсарна. Тулгууруудын хоорондын зай: ф250мм - 7м, ф200мм - 6м, ф150мм - 5м, ф125мм - 4.5м, ф100мм - 4 м, ф89мм - 3.5м, ф57, 76мм - 3м, ф40мм - 2.5м, ф32мм - 2м, ф25мм - 1,7м-т тус тус байна. Шугам хоолойг зэврэлтээс хамгаалах түрхлэгийг 2 дахин хийж, 50 мм зузаантай пенополиуретанаар дулаалан, гадуур нь ус чийгэнд тэсвэртэй материалаар ам дарж нягт орооно.
11. Хоолойн угсралт, туршилт тохируулгыг БНбД 3.05.03-95 "Дулааны шугам сүлжээ"-н дагуу гүйцэтгэнэ.
12. Барилга угсралтын явцад төсөлд тусгасан шийдлийг өөрчлөх шаардлага гарвал зохиогчтой зөвшөөрөлцөх хэрэгтэй.
13. Газар шорооны ажил эхлэхийн өмнө цахилгаан, холбооны суваг, кабелийн байршлыг тогтоон холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авах ба угсралтын үед дагаж мөрдөх техник аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлах хэрэгтэй.
14. Дулааны худгуудад байгаа хэрэглэгчийн холболтуудыг буцаан холбоно.

DHT УБ. БГД 11-р хороо Энэбишийн өргөн чөлөө 78-р байр 204 тоот Утас: 7604 4780 "ДНТ" ХХК	Төв аймаг. Зуунмод сум. 1-р баг. ХАЛААЛТЫН 2-Р ЗУУХНЫ ХОЁРДУГААР ХЭЛХЭЭНИЙ ШУГАМ СҮЛЖЭЭ					
	Орчны тойм, тайлбар, үндсэн үзүүлэлт					Үе шат: А.З
	Инженер		Л.Энхсайхан	ЕГ Шифр: ДНТ-10-2/2019.24	Масштаб: М1:4000	Хуудас: 207
	Гүйцэтгэсэн		Э.Бат-Эрдэнэ	ТГ Шифр:	Зургийн дугаар: ГДГ-7	Огноо: 2024.04.15
	Шалгасан		М.Буянхишиг			

А3

8

ЗӨВШӨӨРСӨН:

"Төв чандмант-ДЭХГ" ОНӨААТҮГ-ын дарга /Ц.Батсүх/

"Төв чандмань-ДЭХГ" ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер /С.Отгонцэцэг/

N

Дулааны шугамын байгууламтын төйм
М1:2500

Томъёолсон тэмдэг

Тэмдэг	Нэр
41	Одоо байгаа барилга
	Төлөвлөж буй дулаан цэвэр усны суваг, шугам
	Төлөвлөж буй "П" хэлбэрийн зөөлөвч /компенсатор/
	Төлөвлөж буй дулааны худаг, үл хөдлөх тулгуур
	2020-2023 онд хийгдсэн шугам сүлжээ
	Одоо байгаа дулаан цэвэр усны суваг, шугам
	Одоо байгаа 0.4кВ-ын кабель, шугам
	Одоо байгаа холбооны кабель, сувагчлал
	Одоо байгаа 10 ба 6 кВ-ын кабель
	Одоо байгаа цэвэр усны шугам
	Одоо байгаа бохир усны шугам

Аймгийн ЗДТГ

2023 онд гүйцэтгэсэн.
ДХ-13 - ДХ-17 хүртэл.
Нийт 197.5 у/м

Халаалтын 2-р хэсэг
тогооны барилга

2560m2

Бөхийн өргөө

Хянасан:

Төв аймгийн ГХБХБГ-ын инженер Ц.Нямгарав

УБ. БГД 11-р хороо
Энэбишийн өргөн чөлөө
78-р байр 204 тоот
Утас: 7604 4780

"ДНТ" ХХК

Төв аймаг. Зуунмод сум. 1-р баг.

ХАЛААЛТЫН 2-Р ЗУУХНЫ ХОЁРДУГААР ХЭЛХЭЭНИЙ ШУГАМ СҮЛЖЭЭ

Дулааны шугамын байгууламтын төйм

Үе шат: А.3

Инженер		Л.Энхсайхан	ЕГ Шифр: ДНТ-10-2/2019.24	Масштаб: М1:2500	Хуудас: 207
Гүйцэтгэсэн		Э.Бат-Эрдэнэ			
Шалгасан		М.Буянхишиг	ТГ Шифр:	Зургийн дугаар: ГДГ-8	Огноо: 2024.04.15

А3

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

"МОНФАЛУ КОНСАЛТИНГ" ХХК



2025 онд санхүүжих

Халаалтын зуух №2 –оос ДХ-13 хүртэл трассын урт 461 у/м

2026 онд санхүүжих

ДХ-8 аас ДХ-8.8 хүртэл, трассын урт 189 у/м

ДХ-13 аас Барилга хүртэл, трассын урт 132 у/м

ДХ-1 ээс ДХ-1.1 хүртэл, трассын урт 38 у/м

Нэмэлтээр хийх ажил

ДХ-10 аас Музей хүртэл, хөнгөлөлтийн зөрүү 174 у/м

НИЙТ 994.5 у/м (461+359+174)

7

Дулааны шугамын байгуулалтын тойм
M1:2000

2025 оны ажлын гүйцэтгэл болон
2026 оны ажлын тоо хэмжээ гаргасан
"ДНТ" ХХК инженер Г. Джирмаа.



2025 онд санхүүжих-Халаалтын зуух №2-с ДХ-13 хүртэл трассын урт 461 у/м

2026 онд санхүүжих-ДХ-8-с ДХ-8.8, ДХ-13-с Барилга, ДХ-1-с ДХ-1.1 хүртэл трассын урт 359 у/м

Нэмэлтээр хийх ажил-Хөнгөлөлтийн зөрүү ДХ-10-с Музей хүртэл трассын урт 174 у/м

УБ. БГД 11-р хороо
Энэбишийн өргөн чөлөө
78-р байр 204 тоот
Утас: 7604 4780
"ДНТ" ХХК

Төв аймаг. Зуунмод сум. 1-р баг.

ХАЛААЛТЫН 2-Р ЗУУХНЫ ХОЁРДУГААР ХЭЛХЭЭНИЙ ШУГАМ СҮЛЖЭЭ

Дулааны шугамын байгуулалтын тойм

Инженер		Л.Энхсайхан	ЕГ Шифр: ДНТ-10-2/2019.24	Масштаб: M1:2000	Үе шат: А.3
Гүйцэтгэсэн		Э.Бат-Эрдэнэ			Хуудас: 207
Шалгасан		М.Буянхишиг	ТГ Шифр:	Зургийн дугаар: ГДГ-7	Огноо: 2024.04.15